

“МОНГОЛЫН МАРКЕТИНГИЙН СУДАЛГААНЫ АССОЦИАЦИ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1 “Монголын маркетингийн судалгааны ассоциаци” ТББ /цаашид байгууллага гэх/ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.
- 1.2 Энэхүү дүрмийн зорилго нь тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго, удирдлагын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Байгууллага нь өөрийн бэлгэдэл, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Байгууллагын оноосон нэр, эрх зүйн болон зохион байгуулалтын хэлбэр

- 2.1 Оноосон нэр :
“Монголын Маркетингийн Судалгааны Ассоциаци” бөгөөд Англи хэл дээр “Mongolian Market Research Association” гэж хөрвөх ба “MMRA” гэсэн товчлолтой байна.
- 2.2 Эрх зүйн хэлбэр : Төрийн бус байгууллага
- 2.3 Зохион байгуулалтын хэлбэр: Гишүүнчлэлтэй

Гурав. Байгууллагын албан ёсны хаяг, байршил

Аймаг, хот : Улаанбаатар хот.

Сум, дүүрэг : Баянзүрх дүүрэг.

Баг, хороо : III хороо.

Гудамж, хороолол: Их тойруу

Оршин байх хаяг: ХД-43 байрны 01 тоот

Шуудангийн хайрцагны №: Монгол шуудан ХК-ийн 49-р салбар

Е мэйл хаяг : mmra@gmail.com

Дөрөв. Үүсгэн байгуулсан он сар өдөр

4.1 Үүсгэн байгуулагчдын 2013 оны 10 сарын 09-ний өдрийн хурлаар үүсгэн байгуулагдав.

Тав. Байгууллагын зорилго, зорилт

5.1 Маркетингийн судалгааны чиглэлээрх стандарт, ёс зүйг сурталчлан таниулж, улмаар судалгааг Монгол улсад мэргэжлийн, өндөр түвшинд хөгжүүлэхэд салбарын байгууллагуудын оролцоог хангах зорилготой байна.

5.2 Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараахь үйл ажиллагааг явуулна.

- Сургалт, семинар, уулзалт, үзэсгэлэн яармаг зохион байгуулах;
- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Гадаад, дотоодын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Мэдээлэл, зөвлөгөө өгөх
- Зорилгод нийцсэн бусад арга хэмжээг зохион байгуулах;

Зургаа. Байгууллагын бүтэц, удирдлагын зохион байгуулалт

6.1 Монголын маркетингийн судалгааны ассоциаци ТББ нь Удирдах зөвлөл, Удирдах зөвлөлийн дарга, Хяналтын зөвлөл, Гүйцэтгэх удирдлага гэсэн бүтэцтэй байна.

Удирдах зөвлөл, түүний бүрэн эрх

6.2 Байгууллагын эрх барих удирдлага нь Удирдах зөвлөл байна.

6.3 Удирдах зөвлөл нь 5 болон түүнээс доошгүй, сондгой тооны гишүүнтэй байна.

6.4 Удирдах зөвлөлийн гишүүнийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр сонгож батална.

6.5 Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд хоёр удаа улиран сонгож болно.

6.6 Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.6.1 Байгууллагын бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох

7.6.2 Удирдах зөвлөлийн даргыг сонгох

7.6.3 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.6.4 Байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах

7.6.5 Байгууллагын жилийн төсөв батлах

7.6.6 Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх

7.6.7 Байгууллагын өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар гүйцэтгэх захирлын эрх, хэмжээг тогтоох

7.6.8 Байгууллагын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах

6.7 Удирдах зөвлөлийн гишүүд хамтын шийдвэр гаргах бөгөөд бүрэн эрхээ хурлаар хэрэгжүүлнэ.

6.8 Удирдах зөвлөл нь ээлжит болон ээлжит бус хуралтай байна.

6.9 Ээлжит хурал нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

6.10 Ээлжит бус хурлыг удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр буюу удирдах зөвлөлийн 2-оос доошгүй гишүүдийн хүсэлтээр ажлын өдөр зарлан хуралдуулж болно.

6.11 Удирдах зөвлөлийн хурлын гишүүдийн 2/3 хувь хуралд оролцсноор хуралдааны ирцийг хүчинтэйд тооцно.

6.12 Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байна. Удирдах зөвлөлийн тогтоолд удирдах зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Удирдах зөвлөлийн дарга, түүний бүрэн эрх

6.13 Удирдах зөвлөлийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.13.1 Байгууллагыг гадаад, дотоодод төлөөлөх

6.13.2 Удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах

6.13.3 Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах

6.13.4 Хуулиар олгогдсон бусад бүрэн эрх

Гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх

6.14 Гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

6.15 Гүйцэтгэх удирдлага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.15.1 Гүйцэтгэх албыг удирдлагаар хангах

7.15.2 Байгууллагыг төлөөлөх

7.15.3 Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд байгууллагын өмч хөрөнгийг захиран зарцуулах

7.15.4 Гэрээнд заасан бүрэн эрх

Хяналтын зөвлөл, түүний бүрэн эрх

6.16 Хяналтын зөвлөл нь 3 гишүүнтэй байна.

6.17 Гүйцэтгэх удирдлагыг хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллахыг хориглоно.

6.18 Хяналтын зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.16.1 Дүрмийн биелэлтэд хяналт тавих

7.16.2 Удирдах Зөвлөлийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хянах

7.16.3 Санхүү, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих

7.16.4 Аливаа маргааны магадлах, шийдвэрлэх

Долоо. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.2 Удирдах зөвлөлийн шийдвэрээр дүрмийг шинэчилж баталснаар хүчин төгөлдөр болно.

Найм. Байгууллагын санхүүжилт

8.1 Байгууллагын орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

8.1.1 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив

8.1.2 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого

8.1.3 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө